



ХАН-УУЛ  
ДҮҮРГИЙН  
НИЙГЭМ,  
ЭДИЙН  
ЗАСГИЙН  
БАЙДАЛ

# ХАН-УУЛ ДҮҮРГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

2022/06



<http://www.ubstat.mn>

АГУУЛГА

|                                                                                     |                                                              |    |
|-------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------|----|
|    | ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, 2020–2022 ОН | 2  |
|    | БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД                                     | 3  |
|    | НИЙГМИЙН ДААТГАЛ                                             | 4  |
|    | НИЙГМИЙН ХАЛАМЖ                                              | 6  |
|    | ЭРҮҮЛ МЭНД                                                   | 7  |
|    | АМЬДАРЧ БУЙ ОРЧИН                                            | 8  |
|   | ГЭМТ ХЭРЭГ                                                   | 10 |
|  | ДҮҮРГИЙН ТӨСӨВ                                               | 12 |
|  | ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ                                              | 14 |
|  | ХӨДӨӨ АЖ АХУЙ                                                | 18 |
|  | АЖ ҮЙЛДВЭР                                                   | 19 |
|  | ТЭЭВЭР                                                       | 22 |
|                                                                                     | ЗАХИРГААНЫ МЭДЭЭЛЭЛ                                          | 23 |

ХҮСНЭГТ 1. ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, жил бүрийн I-VI сард

| Үзүүлэлт                                   | Хэмжих нэгж | 2020     | 2021     | 2022      |
|--------------------------------------------|-------------|----------|----------|-----------|
| Суурин хүн ам, сарын эцэст                 | хүн         | 189 248  | 197 395  | 209 783   |
| Шинээр төрсөн хүүхэд                       | тоо         | 2 330    | 2 446    | 2 219     |
| Бүртгэлтэй ажилгүй иргэд, сарын эцэст      | хүн         | 554      | 478      | 768       |
| үүнээс: эмэгтэй                            | хүн         | 287      | 235      | 395       |
| Халдварт өвчнөөр өвчилсөн хүн              | тоо         | 564      | 12 614   | 24 599    |
| Бүртгэгдсэн гэмт хэрэг                     | тоо         | 895      | 891      | 1 444     |
| Хэрэглээний үнийн индексийн сарын өөрчлөлт | хувь        | 0.4      | 0.9      | 1.5       |
| Валютын зах зээлийн ханш, сарын эцэст      | 1US\$ =₮    | 2 816.0  | 2 849.1  | 3 134.1   |
| Дүүргийн төсвийн орлого                    | сая төгрөг  | 52 160.3 | 90 226.5 | 170 141.4 |
| Дүүргийн төсвийн зарлага                   | сая төгрөг  | 48 852.4 | 51 777.5 | 90 402.7  |



## БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД


Бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 2022 оны 6 дугаар сард 768 байгаа нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 290 хүнээр нэмэгдсэн байна. Нийт ажилгүйчүүдийн 395 (51.4 %) эмэгтэйчүүд байна.

2022 оны 6 дугаар сард орон тооны цомхотголоор 27, мэргэжил, эрүүл мэндийн хувьд тэнцэхгүй 7, өөр газраас шилжиж ирсэн 14, сургууль төгссөн 15, бусад шалтгаанаар 327 хүн ажилгүй болжээ. Тайлант сард 105 ажилд орсноос төсөвт байгууллагад 73, нөхөрлөл компанид 32 хүн ажилд орсон.

### ХҮСНЭГТ 2. БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙЧҮҮД, боловсролын түвшнээр, 2022 VI сард

| Үзүүлэлт                            | Ажилгүйчүүдийн тоо |            |            | Дүнд эзлэх хувь |              |              |
|-------------------------------------|--------------------|------------|------------|-----------------|--------------|--------------|
|                                     | 2020 VI            | 2021 VI    | 2022 VI    | 2020 VI         | 2021 VI      | 2022 VI      |
| <b>Нийт ажилгүйчүүд</b>             | <b>554</b>         | <b>478</b> | <b>768</b> | <b>100.0</b>    | <b>100.0</b> | <b>100.0</b> |
| Дээд боловсролтой                   | 255                | 205        | 441        | 46.0            | 42.9         | 57.4         |
| Тусгай дунд боловсролтой            | 24                 | 19         | 23         | 4.3             | 4.3          | 3.0          |
| Мэргэжлийн анхан шатны боловсролтой | 20                 | 18         | 19         | 3.6             | 3.6          | 2.5          |
| Бүрэн дунд боловсролтой             | 235                | 209        | 271        | 42.4            | 42.4         | 35.3         |
| Бүрэн бус дунд боловсролтой         | 13                 | 22         | 10         | 2.4             | 2.4          | 1.3          |
| Бага, боловсролгүй                  | 7                  | 5          | 4          | 1.3             | 1.3          | 0.5          |

### ЗУРАГ 1. АЖИЛГҮЙЧҮҮД насны бүлгээр, 2022 VI сард



2022 оны 6 дугаар сард 390 хүн шинээр бүртгүүлсэн байгааг ажил хайж буй шалтгаанаар нь авч үзвэл 237 (60.8%) хүн ажлаас чөлөөлөгдсөн болон халагдсан иргэд байна.

Насны бүлгээр авч үзвэл нийт бүртгэлтэй ажилгүйчүүдийн 35 (4.6%) нь 15-24 насны, 297 (38.7%) нь 25-34 насны, 250 (32.6%) нь 35-44 насны, 186 (24.1%) нь 45-60 насны хүмүүс байна.



## НИЙГМИЙН ДААТГАЛ

2022 оны эхний 6 сард Хан-Уул дүүргийн нийгмийн даатгалын салбарын үйлчилгээнд 5534 байгууллагын нийт 138.1 мянга гаруй хүн хамрагдаж, шимтгэл төлсөн ба тэдгээрийн 88534 (64.1%) нь ААНБ-ын, 11822 (8.6%) нь төсвийн байгууллагын, 7929 (5.7%) нь сайн дурын даатгуулагчид, 29805 (21.6%) нь эрүүл мэндийн даатгалд хамрагдсан даатгуулагчид байна.

### ХҮСНЭГТ 3. НИЙГМИЙН ДААТГАЛЫН БАЙГУУЛЛАГААР ҮЙЛЧЛҮҮЛСЭН БАЙГУУЛЛАГА БОЛОН ДААТГУУЛАГЧИЙН ТОО, 2022 оны эхний VI сард

| Үзүүлэлт                               | 2021 I-VI | 2022 I-VI | Өсөлт/ Бууралт |      |
|----------------------------------------|-----------|-----------|----------------|------|
|                                        |           |           | тоо            | хувь |
| Нийт байгууллагын тоо                  | 4 423     | 5 534     | 1111           | 25.1 |
| Аж ахуйн нэгж байгууллагын тоо         | 4 301     | 5 407     | 1106           | 25.7 |
| Төсөвт байгууллагын тоо                | 122       | 127       | 5              | 4.1  |
| Нийт даатгуулагчдын тоо                | 108 704   | 138 090   | 29386          | 27.0 |
| ААНБ-ын даатгуулагчийн тоо             | 74 981    | 88 534    | 13553          | 18.1 |
| Төсөвт байгууллагын даатгуулагчийн тоо | 11 201    | 11 822    | 621            | 5.5  |
| Сайн дурын даатгуулагчийн тоо          | 7 561     | 7 929     | 368            | 4.9  |
| Эрүүл мэндийн даатгуулагчийн тоо       | 14 961    | 29 805    | 14844          | 99.2 |

2022 оны эхний 6 сард дүүргийн нийгмийн даатгалын сангийн нийт орлого 196.9 тэрбум төгрөг болж төлөвлөснөөс 11.1 (6.0%) тэрбум төгрөгөөр илүү бүрдсэн байна. Орлогын төлөвлөгөөний биелэлтийн хувийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.9 пунктээр буурсан үзүүлэлттэй байна.


### ХҮСНЭГТ 4. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, сан тус бүрээр, 2022 оны эхний VI сард

| Үзүүлэлт                               | Төлөвлөгөө |           | Гүйцэтгэл |           | Биелэлт % |           |
|----------------------------------------|------------|-----------|-----------|-----------|-----------|-----------|
|                                        | 2021 I-VI  | 2022 I-VI | 2021 I-VI | 2022 I-VI | 2021 I-VI | 2022 I-VI |
| Тэтгэврийн даатгалын сангийн орлого    | 80 688.6   | 135 034.1 | 94 783.3  | 141 629.9 | 117.5     | 104.9     |
| Тэтгэмжийн сангийн орлого              | 5 955.5    | 11 450.5  | 3 362.7   | 12 953.0  | 56.5      | 113.1     |
| ҮОМШӨ*-ний даатгалын орлого            | 5 944.9    | 10 118.9  | 3 020.1   | 11 088.4  | 50.8      | 109.6     |
| Ажилгүйдлийн даатгалын сангийн орлого  | 1 200.6    | 2459.8    | 642.1     | 4 529.7   | 53.5      | 184.1     |
| Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого | 21 764.4   | 26 669.5  | 21 764.4  | 26 669.5  | 100.0     | 100.0     |
| Нийт                                   | 115 554.0  | 185 732.8 | 123 572.6 | 196 870.5 | 106.9     | 106.0     |


Тайлбар: ҮОМШӨ-Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин

Даатгалын санд хуримтлуулсан нийт шимтгэлийн орлогын 71.9 хувийг тэтгэврийн даатгалын санд, 6.6 хувийг тэтгэмжийн даатгалын санд, 5.6 хувийг ҮОМШӨ-ний даатгалын санд, 2.3 хувийг ажилгүйдлийн даатгалын санд, 13.5 хувийг эрүүл мэндийн даатгалын сангийн орлого тус тус эзэлж байна.

ЗУРАГ 2. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН САНГИЙН ОРЛОГЫН БҮТЭЦ, хувиар



ЗУРАГ 3. НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЗАРЛАГЫН БҮТЭЦ, хувиар




Тэтгэврийн даатгалын сангаас өндөр насны тэтгэвэр авагч 18368 хүнд 66.3 тэрбум төгрөгийг, тахир дутуугийн тэтгэвэр авагч 3361 хүнд 8.5 тэрбум төгрөгийг, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагч 891 хүнд 2.4 тэрбум төгрөгийг, цэргийн тэтгэвэр авагч 1323 хүнд 6.6 тэрбум төгрөгийг тус тус олгосон байна.

Тэтгэмжийн даатгалын сангаас хөдөлмөрийн чадвар түр алдсан 9806 хүнд 1.8 тэрбум төгрөгийг, жирэмсэн болон амаржсан 2449 хүнд 5.8 тэрбум төгрөгийг, 32 хүнд оршуулгын тэтгэмж 32 сая төгрөгийг тус тус олгожээ.

ҮОМШӨ-ний даатгалын сангаас тахир дутуугийн тэтгэвэр авагч 161 хүнд 605 сая төгрөгийг, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагч 18 хүнд 88.7 сая төгрөгийг, тэтгэмж төлбөрт 86 хүнд 70.1 сая төгрөгийг, цэргийн тэтгэвэр авагч 10 хүнд 1.8 тэрбум төгрөгийг тус тус олгосон байна. Ажилгүйдлийн тэтгэмж авсан 1572 хүнд 4.7 тэрбум төгрөг зарцуулжээ.

Нийгмийн даатгалын сангийн нийт зардлын 71.5 хувийг тэтгэврийн, 6.6 хувийг тэтгэмжийн, 5.7 хувийг ҮОМШӨ-ний, 2.4 хувийг ажилгүйдлийн, 13.8 хувийг эрүүл мэндийн даатгалын сангаас олгосон зардал эзэлж байна.

ЗУРАГ 4. ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, сая төг



ЗУРАГ 5. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ТЭТГЭВЭР АВАГЧДЫН ТОО





## НИЙГМИЙН ХАЛАМЖ

2022 оны эхний 6 сард нийгмийн халамжийн сангийн олголтын мэдээгээр нийт 11.7 хувь нь нийгмийн халамжийн сан, 78.7 хувь нь хүүхдийн мөнгө, 0.6 хувь нь жирэмсэн болон нярай, хөхүүл, хүүхэдтэй, 2.0 хувь нь алдарт эхийн одонгийн тусламж, 2.3 хувь нь насны хишиг, 4.3 хувь нь цалинтай ээж хөтөлбөр, 0.4 хувь нь ахмад цолтон, өрх толгойлсон эцэг эх, онцгой тохиолдлын орлогод тус тус хуваарилсан байна. Харин зарлагын 78.7 хувь нь хүүхдийн мөнгө буюу нийт 89987 хүнд, 11210 хүнд алдарт эхийн одонгийн тусламж, 38 хүнд алдар цолтой ахмадын хөнгөлөлт, тусламж, 15174 хүнд эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмжид тус тус зарцуулсан байна.

ХҮСНЭГТ 5. НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ, 2022 оны эхний VI сард, сая.төг

| Үзүүлэлт                                                        | Дүн             | Хүний тоо      |
|-----------------------------------------------------------------|-----------------|----------------|
| <b>Нийгмийн халамжийн сангийн орлого</b>                        | <b>67 669.4</b> |                |
| Улсын төсвийн санхүүжилтийн орлого                              | 67 669.4        |                |
| Нийгмийн халамжийн сан                                          | 7 890.9         |                |
| Жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн мөнгөн тэтгэмж | 426.8           |                |
| Алдарт эхийн одонгийн тусламж                                   | 1 353.3         |                |
| Насны хишиг                                                     | 1 579.2         |                |
| Хүүхдийн мөнгө                                                  | 53 244.0        |                |
| Цалинтай ээж хөтөлбөр                                           | 2 897.4         |                |
| Ахмад цолтон ахмадын хөнгөлөлт, тусламж                         | 13.5            |                |
| Өрх толгойлсон эцэг эхэд олгох тэтгэмж                          | 242.7           |                |
| Онцгой тохиолдолд олгох тэтгэмж                                 | 21.6            |                |
| <b>Зарлагын нийт дүн</b>                                        | <b>67 669.4</b> | <b>142 769</b> |
| Нийгмийн халамжийн сан                                          | 7 890.9         | 16 272         |
| Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмж            | 3 566.9         | 15 174         |
| Алдарт эхийн одонгийн тусламж                                   | 1 353.3         | 11 210         |
| Алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж             | 13.5            | 38             |
| Хүүхдийн мөнгө                                                  | 53 244.0        | 89 987         |
| Насны хишиг                                                     | 1 579.2         | 10 070         |
| Онцгой тохиолдолд олгох тэтгэмж                                 | 21.6            | 18             |





## ЭРҮҮЛ МЭНД

Дүүргийн хэмжээнд 2022 оны эхний 6 сард 24 599 хүн халдварт өвчнөөр өвчилсөн нь өмнөх оны мөн үеэс 11985 хүнээр (1.9 дахин), 10 000 хүн тутмаас халдварт өвчнөөр өвчилсөн хүний тоо 551.5 процидмилээр нэмэгдсэн байна.

Халдварт өвчнөөр өвчлөгчдийн 98.5 хувийг ковид-19, 0.4 хувийг шинээр илэрсэн сүрьеэ, 0.5 хувийг салхин цэцэг, 0.2 хувийг цусан суулга, 0.1 хувийг гар хөл, амны өвчин, 0.1 хувийг тэмбүү, 0.2 хувийг бусад өвчнөөр өвчлөгчид тус тус эзэлж байна.


### ХҮСНЭГТ 6. ДҮҮРЭГТ ГАРСАН ХАЛДВАРТ ӨВЧИН, жил бүрийн эхний VI сард

| Үзүүлэлт                   | Хэмжих нэгж                     | 2021 I-VI               | 2022 I-VI                 | Өсөлт, бууралт<br>2022/2021 |                        |
|----------------------------|---------------------------------|-------------------------|---------------------------|-----------------------------|------------------------|
|                            |                                 |                         |                           | тоо/пункт                   | Хувь                   |
| <b>НИЙТ ХАЛДВАРТ ӨВЧИН</b> | <b>Бодит тоо<br/>10000 хүнд</b> | <b>12 614<br/>661.9</b> | <b>24 599<br/>1 213.4</b> | <b>11 985<br/>551.5</b>     | <b>1.9<sup>1</sup></b> |
| Вируст гепатит             | Бодит тоо<br>10000 хүнд         | 1<br>0.1                | 7<br>0.5                  | 6<br>0.4                    | 7 <sup>1</sup>         |
| Цусан суулга               | Бодит тоо<br>10000 хүнд         | 1<br>0.1                | 44<br>2.2                 | 43<br>2.1                   | 44 <sup>1</sup>        |
| Улаан эсэргэнэ             | Бодит тоо<br>10000 хүнд         | 0<br>0                  | 5<br>0.2                  | 5<br>0.2                    | 0                      |
| Сальмонеллёз               | Бодит тоо<br>10000 хүнд         | 0<br>0                  | 10<br>0.5                 | 10<br>0.5                   | 0                      |
| Салхин цэцэг               | Бодит тоо<br>10000 хүнд         | 0<br>0                  | 115<br>5.7                | 115<br>5.7                  | 0                      |
| Гахайн хавдар              | Бодит тоо<br>10000 хүнд         | 0<br>0                  | 1<br>0.1                  | 1<br>0.1                    | 0                      |
| Ёлом                       | Бодит тоо<br>10000 хүнд         | 0<br>0                  | 3<br>0.1                  | 3<br>0.1                    | 0                      |
| Гар хөл, амны өвчин        | Бодит тоо<br>10000 хүнд         | 1<br>0.1                | 25<br>1.2                 | 24<br>1.1                   | 25 <sup>1</sup>        |
| Тэмбүү                     | Бодит тоо<br>10000 хүнд         | 17<br>0.9               | 31<br>1.5                 | 14<br>0.6                   | 82.3                   |
| Заг хүйтэн                 | Бодит тоо<br>10000 хүнд         | 19<br>1.0               | 12<br>0.6                 | -7<br>-0.4                  | -36.8                  |
| Трихомониаз                | Бодит тоо<br>10000 хүнд         | 16<br>0.8               | 8<br>0.4                  | -8<br>-0.4                  | -50.0                  |
| Шинээр илэрсэн сүрьеэ      | Бодит тоо<br>10000 хүнд         | 76<br>4.0               | 105<br>5.2                | 29<br>1.2                   | 38.1                   |
| Мөөгөнцөр                  | Бодит тоо<br>10000 хүнд         | 2<br>0.1                | 0<br>0                    | -2<br>-0.1                  | -100.0                 |
| Ковид 19                   | Бодит тоо<br>10000 хүнд         | 12 478<br>654.7         | 24 231<br>1 195.3         | 11 753<br>540.6             | 94.2                   |
| Бусад өвчлөл               | Бодит тоо<br>10000 хүнд         | 3<br>0.2                | 2<br>0.1                  | -1<br>-0.1                  | -33.3                  |


<sup>1</sup> дахин их



ЗУРАГ 6. АМАРЖСАН ЭХ, АМЬД ТӨРСӨН ХҮҮХЭД



ЗУРАГ 7. ХАЛДВАРТ ӨВЧНӨӨР ӨВЧЛӨГЧИД




2022 оны эхний 6 сард төрөхийн улмаас эндсэн эхийн тоо өмнөх оны мөн үеэс 1 эхээр буурч, нялхсын эндэгдэл 6 хүүхдээр, 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 3 хүүхдээр нэмэгдсэн байна.

ХҮСНЭГТ 7. ТӨРСӨН ХҮҮХЭД, ЭХ, ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ, жил бүрийн эхний VI сард

| Үзүүлэлт                          | 2020 I-VI | 2021 I-VI | 2022 I-VI | $\frac{2022}{2021}$ % |
|-----------------------------------|-----------|-----------|-----------|-----------------------|
| Амаржсан эхийн тоо                | 2 310     | 2 420     | 2 205     | -8.9                  |
| Амьд төрсөн хүүхэд                | 2 330     | 2 446     | 2 219     | -9.3                  |
| Төрөхийн улмаас эндсэн эх         | -         | 4         | 3         | -25.0                 |
| Нэг хүртэл насандаа эндсэн хүүхэд | 15        | 15        | 21        | 40.0                  |
| 1-5 хүртэл насандаа эндсэн хүүхэд | 1         | 2         | 5         | 2.5 <sup>1</sup>      |

Эх үүсвэр: Хан-Уул дүүргийн Эрүүл мэндийн төв

<sup>1</sup> дахин их



## АМЬДАРЧ БҮЙ ОРЧИН

Нийслэлийн агаарын дундаж хэм 2022 оны 6 дугаар сард дунджаар 17.1<sup>0</sup>C байв. Энэ нь өмнөх оны мөн үеэс 2.3<sup>0</sup>C-аар, олон жилийн дундажтай харьцуулбал 0.5<sup>0</sup>C-аар дулаан байв. Энэ сарын хамгийн дулаан хэм 30.9<sup>0</sup>C, хамгийн хүйтэн хэм 4.4<sup>0</sup>C, хур тунадасны нийлбэр 50.4 миллиметр, салхины үнэмлэхүй их хурд 17 метр секунд хүрсэн байна.

ХҮСНЭГТ 8. АГААРЫН БОХИРДОЛТ, мг/м<sup>3</sup>, VI сард<sup>1</sup>

| Бодисын нэр                            |                   | Стандарт хэмжээ | Хэмжилтийн тоо | Хамгийн их хэмжээ | Стандарт хэмжээнээс давсан тохиолдлын тоо | Агаарт байсан дундаж хэмжээ |
|----------------------------------------|-------------------|-----------------|----------------|-------------------|-------------------------------------------|-----------------------------|
| Хүхэрлэг хий                           | SO <sub>2</sub>   | 0.050           | 274            | 0.043             | -                                         | 0.010                       |
| Азотын давхар исэл                     | NO <sub>2</sub>   | 0.050           | 281            | 0.069             | 32                                        | 0.024                       |
| Тоосжилт                               | PM <sub>10</sub>  | 0.100           | 384            | 0.240             | 35                                        | 0.054                       |
|                                        | PM <sub>2.5</sub> | 0.050           | 216            | 0.052             | 1                                         | 0.052                       |
| Нүүрстөрөгчийн дутуу исэл <sup>2</sup> | CO                | 10.000          | 942            | 2.429             | -                                         | 0.335                       |
| Озон                                   | O <sub>3</sub>    | 0.100           | 488            | 0.100             | -                                         | 0.050                       |

<sup>1</sup> Эх үүсвэр: Цаг уур, орчны шинжилгээний газар

<sup>2</sup> 8 цагийн дундаж

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2022 оны 6 дугаар сард Улаанбаатар хотын агаар дахь хүхэрлэг хийн дундаж агууламж  $0.001 \text{ мг/м}^3$  (5.2%)-ээр, азотын давхар ислийн дундаж агууламж  $0.001 \text{ мг/м}^3$  (3.2%)-ээр их,  $\text{PM}_{2.5}$  тоосонцорын дундаж агууламж  $0.003 \text{ мг/м}^3$  (24.9%)-аар,  $\text{PM}_{10}$  тоосонцрын дундаж агууламж  $0.009 \text{ мг/м}^3$  (21.0%)-ээр тус тус бага байна.

ХҮСНЭГТ 9. ХАН-УУЛ ДҮҮРГИЙН АГААР ДАХЬ БОХИРДУУЛАГЧ БОДИСЫН ХОНОГИЙН ДУНДАЖ АГУУЛАМЖ,  $\text{мг/м}^3$ , VI сард

| Агаарын бохирдлын үзүүлэлт                   |                   | Мишээл-Экспо төв |       |       | Богд хааны ордон музей | Нисэх |       |       |
|----------------------------------------------|-------------------|------------------|-------|-------|------------------------|-------|-------|-------|
|                                              |                   | 2020             | 2021  | 2022  | 2022                   | 2020  | 2021  | 2022  |
|                                              |                   | $\text{Мг/м}^3$  |       |       |                        |       |       |       |
| Хүхэрлэг хий $\text{SO}_2$                   | Дундаж            | 0.009            | 0.012 | 0.013 | 0.012                  | 0.005 | 0.020 | -     |
|                                              | Хамгийн их XXX*-с | 0.029            | 0.036 | 0.031 | 0.019                  | 0.010 | 0.036 | -     |
|                                              | давсан хувь       | -                | -     | -     | -                      | -     | -     | -     |
|                                              | Хэмжилтийн тоо    | 30               | 27    | 30    | 23                     | 28    | 23    | -     |
| Азотын давхар исэл $\text{NO}_2$             | Дундаж            | -                | 0.030 | -     | 0.024                  | -     | 0.015 | 0.013 |
|                                              | Хамгийн их XXX*-с | -                | 0.044 | -     | 0.040                  | -     | 0.030 | 0.018 |
|                                              | давсан хувь       | -                | -     | -     | -                      | -     | -     | -     |
|                                              | Хэмжилтийн тоо    | -                | 28    | -     | 26                     | -     | 27    | 12    |
| Нүүрс төрөгчийн дутуу исэл, $\text{CO}^{**}$ | Дундаж            | -                | -     | -     | 0.212                  | -     | 0.238 | 0.192 |
|                                              | Хамгийн их XXX*-с | -                | -     | -     | 0.457                  | -     | 0.801 | 0.429 |
|                                              | давсан хувь       | -                | -     | -     | -                      | -     | -     | -     |
|                                              | Хэмжилтийн тоо    | -                | -     | -     | 90                     | -     | 80    | 64    |
| Тоос $\text{PM}_{10}$                        | Дундаж            | 0.072            | 0.049 | 0.039 | 0.039                  | 0.093 | 0.025 | 0.065 |
|                                              | Хамгийн их XXX*-с | 0.174            | 0.130 | 0.079 | 0.097                  | 0.208 | 0.065 | 0.14  |
|                                              | давсан хувь       | 26.0             | 4.0   | -     | -                      | 43.0  | -     | 18    |
|                                              | Хэмжилтийн тоо    | 31               | 27    | 30    | 29                     | 28    | 18    | 17    |
| Тоос $\text{PM}_{2.5}$                       | Дундаж            | -                | -     | -     | 0.002                  | 0.017 | 0.006 | 0.016 |
|                                              | Хамгийн их XXX*-с | -                | -     | -     | 0.015                  | 0.030 | 0.014 | 0.025 |
|                                              | давсан хувь       | -                | -     | -     | -                      | -     | -     | -     |
|                                              | Хэмжилтийн тоо    | -                | -     | -     | 29                     | 28    | 18    | 17    |
| Озон $\text{O}_3^{**}$                       | Дундаж            | 0.021            | -     | -     | -                      | -     | 0.057 | 0.062 |
|                                              | Хамгийн их XXX*-с | 0.041            | -     | -     | -                      | -     | 0.096 | 0.099 |
|                                              | давсан хувь       | -                | -     | -     | -                      | -     | -     | -     |
|                                              | Хэмжилтийн тоо    | 80               | -     | -     | -                      | -     | 80    | 65    |

\* Хүлцэх хэм хэмжээ, \*\* $\text{CO}$ ,  $\text{O}_3$ -ийн хэмжилтийг 8 цагийн дунджаар тооцсон

Эх үүсвэр: “Нийслэлийн эдийн засаг, нийгмийн байдал” статистикийн 2022 оны 6-р сарын танилцуулга

### Туул голын усны бохирдол:

Байгаль орчны хэмжил зүйн төв лабораторийн 2022 оны 6 дугаар сарын 08, 09-ний өдөр хийсэн хэмжилтээр Туул голын усны найрлага Туул-Налайх харуул цэгийн орчимд хэвийн, Туул-Сонгино доод харуул цэгийн орчимд хүчилтөрөгч 0.8 дахин бага, биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч 10.4 дахин, нитритийн нэгдэл 1,2 дахин, амоны азот 9.2 дахин, эрдэс фосфор 4.7 дахин хүлцэх хэмжээнээс давж Туул голын ус бохирдолтой хэвээр байна.

ХҮСНЭГТ 10. НИЙСЛЭЛИЙН ГАДАРГЫН УСНЫ НАЙРЛАГА, мг/м<sup>3</sup>, VI сард<sup>3</sup>

| Үзүүлэлт                        |                  | Стандарт хэмжээ | “Туул-Налайх” харуул цэг |                 | “Туул-Сонгино доод” харуул цэг |                 |
|---------------------------------|------------------|-----------------|--------------------------|-----------------|--------------------------------|-----------------|
|                                 |                  |                 | Хэмжээ                   | Бодисын хэтрэлт | Хэмжээ                         | Бодисын хэтрэлт |
| Хүчилтөрөгч                     | O <sub>2</sub>   | ≥6              | 9.8                      | Хэвийн          | 4.58                           | 0.8 дахин бага  |
| Биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч | BXX <sub>5</sub> | ≤ 3             | 1.9                      | Хэвийн          | 31.2                           | 10.4 дахин      |
| Нитритийн нэгдэл                | NO <sub>2</sub>  | ≤ 0.02          | 0.003                    | Хэвийн          | 0.024                          | 1.2 дахин       |
| Амоны азот                      | NH <sub>4</sub>  | ≤0.5            | 0.06                     | Хэвийн          | 4.59                           | 9.2 дахин       |
| Эрдэс фосфор                    | P                | ≤0.1            | 0.004                    | Хэвийн          | 0.471                          | 4.7 дахин       |

<sup>3</sup> Эх үүсвэр: Байгаль орчны хэмжил зүйн төв лаборатори



### ГЭМТ ХЭРЭГ

Дүүргийн хэмжээнд 2022 оны эхний 6 сард 1 444 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 553 (62.1%) хэргээр өссөн байна.

ЗУРАГ 8. ГЭМТ ХЭРГИЙН ТОО, жил бүрийн I-VI сард



Нийт гэмт хэргийн 316 (21.9%) нь хулгайн хэрэг, 302 (20.9%) нь хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг хэрэг, 525 (36.3%) хэрэг нь залилан мэхлэх гэмт хэрэг, 6 (0.4%) нь хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх хэрэг, 19 (1.3%) нь хүчингийн хэрэг, 16 (1.1%) нь дээрэмдэх хэрэг, 45 (3.1%) нь ХАБТХАЖЭ хэрэг, 11 (0.8%) нь хүнийг алах хэрэг, 4 (0.3%) нь малын хулгай, 200 (13.9%) нь бусад гэмт хэргүүд тус тус эзэлж байна.

ХҮСНЭГТ 11. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, төрлөөр, VI сард


| Гэмт хэргийн төрөл                             | Гэмт хэргийн тоо |           | Өсөлт, бууралт        |     |
|------------------------------------------------|------------------|-----------|-----------------------|-----|
|                                                | 2021 I-VI        | 2022 I-VI | $\frac{2022}{2021}\%$ | Тоо |
| Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх       | 9                | 6         | -33.3                 | -3  |
| Хүчин                                          | 7                | 19        | 2.7 <sup>1</sup>      | 12  |
| Дээрэмдэх                                      | 10               | 16        | 60.0                  | 6   |
| Хулгай                                         | 128              | 316       | 2.5 <sup>1</sup>      | 188 |
| Залилан мэхлэх                                 | 286              | 525       | 83.5                  | 239 |
| Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг    | 192              | 302       | 57.3                  | 110 |
| Малын хулгай                                   | -                | 4         | -                     | -   |
| Олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулах | -                | -         | -                     | -   |
| Хүнийг санаатай алах                           | 4                | 11        | 2.7 <sup>1</sup>      | 7   |
| ХАБТХАЖЭ                                       | 28               | 45        | 60.7                  | 17  |
| Бусад                                          | 227              | 200       | -11.9                 | -27 |
| Бүгд                                           | 891              | 1 444     | 62.1                  | 553 |

\*ХАБТХАЖЭ-Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг

<sup>1</sup> дахин их

Нийт 316 хулгайн гэмт хэргийн 280 (88.6%) нь иргэний өмчийн хулгай, 2 (0.6%) нь авто тээврийн хулгай, 34 (10.8%) нь халаасны хулгайн хэрэг эзэлж байна.

ЗУРАГ 9. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, хороогоор



ХҮСНЭГТ 12. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, хороогоор

| Хороо | Гэмт хэрэг |           | Өөрчлөлт |                  | Хүнийг алах | Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх | Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг | Үүнээс<br>Гэр бүлийн хүчирхийлэл | Хүчин | Хулгай | Үүнээс |                                  |                 | Дээрэмдэх | Залилан мэхлэх | Малын хулгай | Олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулах | ХАБТХАЖЭ | Бусад |
|-------|------------|-----------|----------|------------------|-------------|------------------------------------------|---------------------------------------------|----------------------------------|-------|--------|--------|----------------------------------|-----------------|-----------|----------------|--------------|------------------------------------------------|----------|-------|
|       | 2021 I-VI  | 2022 I-VI | Тоо      | Хувь             |             |                                          |                                             |                                  |       |        | ИӨХ    | Авто тээврийн хэрэгсэл хулгайлах | Халаасны хулгай |           |                |              |                                                |          |       |
| Дүн   | 891        | 1 444     | 553      | 62.1             | 11          | 6                                        | 302                                         | 5                                | 19    | 316    | 280    | 2                                | 34              | 16        | 525            | 4            | -                                              | 45       | 200   |
| 1     | 40         | 80        | 40       | 2 <sup>1</sup>   | 1           | 1                                        | 10                                          | -                                | 2     | 17     | 13     | -                                | 4               | 2         | 34             | -            | -                                              | 2        | 11    |
| 2     | 49         | 67        | 18       | 36.7             | -           | 1                                        | 15                                          | -                                | -     | 9      | 9      | -                                | -               | 1         | 36             | -            | -                                              | 1        | 4     |
| 3     | 85         | 105       | 20       | 23.5             | 1           | -                                        | 20                                          | -                                | -     | 14     | 13     | -                                | 1               | 1         | 47             | -            | -                                              | 6        | 16    |
| 4     | 78         | 183       | 105      | 2.3 <sup>1</sup> | 1           | -                                        | 37                                          | -                                | 2     | 45     | 35     | 1                                | 9               | 2         | 67             | -            | -                                              | 9        | 20    |
| 5     | 13         | 21        | 8        | 61.5             | -           | -                                        | 4                                           | -                                | 1     | 4      | 3      | -                                | 1               | -         | 7              | -            | -                                              | 3        | 2     |
| 6     | 14         | 16        | 2        | 14.3             | -           | 1                                        | 5                                           | -                                | 1     | 2      | 1      | -                                | 1               | 1         | 5              | -            | -                                              | 1        | -     |
| 7     | 11         | 21        | 10       | 90.9             | -           | -                                        | 5                                           | 1                                | 1     | 3      | 3      | -                                | -               | -         | 7              | -            | -                                              | 1        | 4     |
| 8     | 34         | 59        | 25       | 73.5             | 2           | -                                        | 14                                          | -                                | 4     | 14     | 13     | -                                | 1               | 1         | 12             | 1            | -                                              | 2        | 9     |
| 9     | 15         | 28        | 13       | 86.7             | -           | -                                        | 10                                          | -                                | 3     | 10     | 10     | -                                | -               | -         | 5              | -            | -                                              | -        | -     |
| 10    | 28         | 51        | 23       | 82.1             | 2           | 1                                        | 17                                          | 2                                | -     | 6      | 6      | -                                | -               | 1         | 18             | -            | -                                              | 1        | 5     |
| 11    | 104        | 138       | 34       | 32.7             | 1           | 2                                        | 28                                          | 1                                | -     | 24     | 20     | 1                                | 3               | -         | 49             | -            | -                                              | 6        | 28    |
| 12    | 14         | 27        | 13       | 92.8             | -           | -                                        | 4                                           | -                                | -     | 11     | 11     | -                                | -               | 1         | 5              | 1            | -                                              | -        | 5     |
| 13    | 13         | 16        | 3        | 23.1             | -           | -                                        | 6                                           | -                                | -     | 2      | 2      | -                                | -               | -         | 5              | 1            | -                                              | -        | 2     |
| 14    | 16         | 51        | 35       | 3.2 <sup>1</sup> | -           | -                                        | 8                                           | -                                | -     | 24     | 24     | -                                | -               | -         | 8              | 1            | -                                              | 4        | 6     |
| 15    | 127        | 191       | 64       | 50.4             | -           | -                                        | 39                                          | -                                | 1     | 39     | 31     | -                                | 8               | 2         | 75             | -            | -                                              | 6        | 29    |
| 16    | 47         | 76        | 29       | 61.7             | 1           | -                                        | 18                                          | -                                | 1     | 31     | 30     | -                                | 1               | 1         | 16             | -            | -                                              | 2        | 6     |
| 17    | 46         | 54        | 8        | 17.4             | 1           | -                                        | 14                                          | -                                | 1     | 10     | 10     | -                                | -               | 1         | 18             | -            | -                                              | -        | 9     |
| 18    | 23         | 42        | 19       | 82.6             | -           | -                                        | 9                                           | -                                | -     | 7      | 7      | -                                | -               | -         | 19             | -            | -                                              | 1        | 6     |
| 19    | 60         | 63        | 3        | 5                | -           | -                                        | 12                                          | 1                                | -     | 5      | 5      | -                                | -               | 1         | 34             | -            | -                                              | -        | 11    |
| 20    | 48         | 86        | 38       | 79.2             | -           | -                                        | 19                                          | -                                | 2     | 13     | 11     | -                                | 2               | 1         | 36             | -            | -                                              | -        | 15    |
| 21    | 26         | 69        | 43       | 2.6 <sup>1</sup> | 1           | -                                        | 8                                           | -                                | -     | 26     | 23     | -                                | 3               | -         | 22             | -            | -                                              | -        | 12    |

\*ХАБТХАЖЭ-Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг


<sup>1</sup> дахин их



## ДҮҮРГИЙН ТӨСӨВ

Дүүргийн төсвийн нийт орлого (урсгал орлого болон тусламжийн орлого) 2022 оны эхний 6 сард 170.1 тэрбум төгрөг болж, төсвийн орлого төлөвлөснөөс 40.5 (19.2%) тэрбум төгрөгөөр дутуу бүрдсэн бөгөөд орлогын бүрдэлт 2021 оноос 88.6 хувь өссөн байна. Төсвийн нийт орлогын 59.8 хувийг татварын орлого (орлогын албан татвар, хөрөнгийн албан татвар, бусад татвар, төлбөр, хураамж), 40.2 хувийг татварын бус орлого (нийтлэг татварын бус орлого, улсын төсөв болон орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг) эзэлж байна.

ЗУРАГ 10. ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, 2013-2022 онд, сая төгрөг



Татварын орлогын хэмжээ 101.7 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 14.2 тэрбум төгрөгөөр (12.3%) дутуу бүрдсэн бол, татварын бус орлого 68.4 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 26.3 тэрбум төгрөгөөр (27.8%) тус тус дутуу бүрдсэн байна.

ХҮСНЭГТ 13. ДҮҮРГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, 2022 оны эхний VI сард, сая төгрөг

| Төсвийн орлого |           |               | Үүнээс:         |           |             |                     |          |             |          |
|----------------|-----------|---------------|-----------------|-----------|-------------|---------------------|----------|-------------|----------|
| Бүгд           | ТБ %      | Зөрүү сая.төг | Татварын орлого |           |             | Татварын бус орлого |          |             |          |
|                |           |               | Бүгд            | ТБ %      | Зөрүү сая.т | Бүгд                | ТБ %     | Зөрүү сая.т |          |
| Дүн            | 170 141.4 | 80.8          | -40 557.1       | 101 693.1 | 87.7        | -14 218.6           | 68 448.3 | 72.2        | 26 338.5 |


Орлогын албан татвар төлөвлөснөөс 15.3 тэрбум төгрөгөөр, хөрөнгийн албан татвар төлөвлөснөөс 326.5 сая төгрөгөөр тус тус дутуу бүрдсэн бол бусад татвар, төлбөр, хураамж төлөвлөснөөс 1.4 тэрбум төгрөгөөр илүү бүрдсэн байна.

ХҮСНЭГТ 14. ДҮҮРГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, 2022 оны эхний VI сард, сая.төг


| Үзүүлэлт                                                | Төлөвлөгөө       | Гүйцэтгэл        | ТБ хувь     | Зөрүү            |
|---------------------------------------------------------|------------------|------------------|-------------|------------------|
| <b>Орон нутгийн орлого</b>                              | <b>210 698.5</b> | <b>170 141.4</b> | <b>80.8</b> | <b>-40 557.1</b> |
| <b>1.Татварын орлогын дүн</b>                           | <b>115 911.7</b> | <b>101 693.1</b> | <b>87.7</b> | <b>-14 218.6</b> |
| 1.1 Орлогын албан татвар                                | 91 445.7         | 76 096.7         | 83.2        | -15 348.9        |
| Хувь хүний орлогын албан татвар                         | 91 445.7         | 76 096.7         | 83.2        | -15 348.9        |
| 1.2 Хөрөнгийн албан татвар                              | 7 535.0          | 7 208.5          | 95.7        | -326.5           |
| 1.3 Бусад татвар,төлбөр, хураамж                        | 16 931.0         | 18 387.9         | 108.6       | 1 456.9          |
| 1.3.1 Бусад нийтлэг төлбөр, хураамж                     | 3 611.0          | 3 801.9          | 105.3       | 190.9            |
| Улсын тэмдэгтийн хураамж                                | 2 900.0          | 2 914.6          | 100.5       | 14.6             |
| Ашигт малтмал ашигласны төлбөр                          | 61.0             | 74.1             | 121.4       | 13.1             |
| Хог хаягдлын үйлчилгээний хураамж                       | 650              | 813.2            | 125.1       | 163.2            |
| 1.3.2 Газрын төлбөр                                     | 13 300           | 14574.9          | 109.6       | 1 274.9          |
| 1.3.3 Байгалийн нөөц ашигласны төлбөр                   | 20               | 11.1             | 55.3        | -8.9             |
| Ус, рашааны нөөц ашигласны төлбөр                       | 20               | 11.1             | 55.3        | -8.9             |
| <b>2.Татварын бус орлогын дүн</b>                       | <b>94 786.9</b>  | <b>68 448.3</b>  | <b>72.2</b> | <b>26 338.5</b>  |
| Нийтлэг бус татварын орлого                             | 1 936.7          | 3 800.9          | 196.3       | 1 864.3          |
| Торгуулийн орлого                                       | 1 800.0          | 3 626.4          | 201.5       | 1 826.4          |
| Төсөвт байгууллагын өөрийн орлого*                      | 118.7            | 153.4            | 129.3       | 34.8             |
